

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

### НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр хуралдаж 3 асуудал, 06 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж 1 асуудал, 6 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж 5 асуудал, 06 дугаар сарын 17-ны өдөр хуралдаж 5 асуудал, 06 дугаар сарын 24-ний өдөр хуралдаж 3 асуудал хэлэлцэж 14 тогтоол шийдвэр гаргаж, 3 асуудалд тэмдэглэлээр үүрэг чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мөн 6 дугаар сард сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарыг “E-OFFICE” программ нэвтрүүлж байгаатай холбогдуулан хэрхэн ашиглах болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад тус тус хамрууллаа.

Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар болон ИТХ-ын Төлөөлөгчдийг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал авах хэлэлцүүлэгт оролцууллаа. Тус хэлэлцүүлэг дээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амарзаяа тодорхой санал хэлж, УИХ-ын гишүүн Ш.Раднаасэдээс холбогдох хариултыг авав.

Ерөнхий сайдын захирамжаар аймгийн Засаг даргаар 2019 оны 06 дугаар сарын –ний өдөр В.Рэнцэндоржийг томилсон бөгөөд ажил хүлээлцэх арга хэмжээ 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр болж аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, Засаг даргын орлогч Ж.Ганбат, Засаг даргын Тамгын газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид оролцлоо.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл 06 дугаар сард нийт 3 удаа хуралдаж, 26 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн “ХҮҮХДИЙН БАЯР”-ын нэгдсэн арга хэмжээг "Хүүхэд бүхэн аз жаргалтай байг" уриан дор 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Монгол Улсын баатар Жанчивын талбайд эхэлсэн тус арга хэмжээг аймгийн засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн С.Гансэлэм нээж, аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад баяр хүргэж үг хэллээ. Энэ үеэр “Оюун санааг орон нутагтаа аян”-ыг санаачлагч зохиолч, яруу найрагч Р.Эмүжин аяныхаа талаар танилцуулж, Есөнбулаг сумын сургуулиуд, аймгийн төв номын санд өөрийн зохиол бүтээлийн дээжээс өргөн барилаа.

Аймгийн хэмжээн дэх бүтэн өнчин 46 хүүхдэд Засаг даргын нэрэмжит 100 мянган төгрөгийг тус тус хадгаламжийн дэвтэрт нь хийлээ.

Ерөнхий сайдын ивээл дор хэрэгжих “Хайртай” төслийг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгууллаа.

Аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, Засаг дарга В.Рэнцэндорж нар “Иргэдээ сонсьё аян”-ыг зохион байгуулж тус аяны хүрээнд 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн бүх сумдад ажиллаж, иргэд, төрийн албан хаагчидтай уулзалт хийж, тэдний

санал бодлыг сонсч, сумдад хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилтай газар дээр нь танилцаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2017-2019 оны эхний хагас жилийн байдлаар хийж хэрэгжүүлсэн онцлог ажлын мэдээллийг боловсрууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/298 дугаар захирамжийн дагуу 2019 оны эхнээс 06 дугаар сарын 15-ныг хүртэлх аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгийн зарцуулалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаа, 2017, 2018 оны сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгө, аймаг дахь Төрийн аудитын газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Дэлхийн банкны “Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран зохион байгуулсан “Төлөвлөлт, хяналт-шинжилгээний уялдааг хангах нь”, НҮБ-ын “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” сэдэвт баруун бүсийн сургалтад 2019 оны 06 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга нар, холбогдох мэргэжилтнүүд нийт 8 хүн хамрагдлаа.

Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсэг 06 дугаар сарын 15-наас 06 дугаар сарын 16 -ны өдрүүдэд аймагт ажиллаж Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, Төрийн албаны тухай хуулийг дагалдан гарсан журам, дүрэм, зааврыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах зорилгоор сургалт зохион байгууллаа.

Сургалтад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар болон түүний хэрэгжүүлэгч агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга нар, сургууль, цэцэрлэгийн удирдлагууд зэрэг нийт 270 орчим төрийн албан хаагч хамрагдлаа.

Мөн ажлын хэсэг аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргын орлогч болон Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүдтэй уулзалт хийв.

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон зарим төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн томилгоо, албан даалгаврын хэрэгжилт, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийн, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Дэлгэр сумын Засаг даргын Тамгын газрыг сонгож хүний нөөцийн томилгоо, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт болон холбогдох эрх зүйн баримт бичигт хяналт, шалгалт хийлээ.

Ажлын хэсэг өргөдөл, гомдол гаргасан албан хаагчид, иргэдийн төлөөлөлтэй уулзаж зөвлөгөө өгч ажилласнаас гадна зарим иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгөх талаар мэдэгдэж ажиллалаа. Мөн аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хамтран төрийн байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 9 ахмадыг хүлээн авч уулзалт хийн Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт ханган ажиллах, сургалт, сурталчилгааг төрийн байгууллагуудад зохион байгуулах талаар ахмадуудтай зөвлөлдөж санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/30 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажлын байрны шинжилгээг журмын дагуу хийж, албан тушаалуудад чиг үүрэг нь албан ёсоор бүрэн хуваарилагдсан, орхигдсон, давхардсан эсэхийг тодорхойлж, чиг үүргийн уялдааг ханган, давхардал хийдлийг арилган, ажлын ачааллыг жигдрүүлэн Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсрууллаа. Төрийн албаны зөвлөлд шинэчлэн боловсруулсан албан тушаалын тодорхойлолтыг тухай бүр хүргэн ажиллалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны хагас жилийн биелэлтэд үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 65.88 хувийн биелэлттэйгээр Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /[unelgee.gov.mn/](http://unelgee.gov.mn/)-д заалт бүрээр байршуулж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ.

Аймгийн хөгжлийн цогц бодлогын 25 зорилтын 135 арга хэмжээ болон 2019 оны эхний хагас жилд гарсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоос аймгийн Засаг дарга, ЗДТГ-т даалгасан заалт бүхий 29 тогтоолын биелэлтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны эхний хагас жилийн биелэлт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

#### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга 06 дугаар сард нийт 310 захирамж гарсанаас 250 захирамжийг байнгын хяналтад авч картлан ажиллаж байна. Захирамжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд аймгийн цахим сайтад байршуулж, биелэлтийг нэгтгэн ажиллаж байна.

“Тайшир-Алтай ус хангамж” төсөл нь Есөнбулаг сумын Индэрт, Баянхайрхан, Жаргалант баг, Тайшир сумын Хуримт багийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил явагдаж байгаа бөгөөд баяр наадмын үеэр аймаг, орон нутгийн хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан ухсан сувагт хүн, мал унаж бэртэж гэмтэх, трассын дагуу буулгасан шугам хоолойд санаатайгаар болон санамсаргүйгээр халдах зэрэг аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ард иргэдэд анхааруулах, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Ундарга-Алтай ОНӨТҮГ- газрын дарга нарт үүрэг чиглэл хүргүүллээ.

“Архигүй-Алтайчууд” хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж ажиллаж байна.

Тайлант сард 10 иргэнд хууль, зүйн зөвөлгөөг үнэ төлбөргүйгээр өгч шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт өрсөн хуулуудаар мэдээллийн хуудас бэлтгэн ажиллаж байна.

Аймгийн прокурорын газарт хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн мэдээний талаар албан бичиг хүргүүллээ.

Мөн аймгийн Засаг даргын А/315 дугаар захирамжаар Архивын тасгийн дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын бүрэлдэхүүн, дүрмийг

шинэчлэн баталж, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газарт, сум, байгууллагуудад мэдээллийг албан бичгээр хүргүүлэв.

Халиун сумын Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч болон улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт аргачлал, судалгаа ирүүлэх талаар 12 байгууллагын ажилтанд зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг явагдахтай холбогдуулан архивын баримтын мэдээ, цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын мэдээ, төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, архивын баримтын хадгалалт хамгаалалтын байдалд зарцуулсан хөрөнгө гэсэн 3 төрлийн судалгааг гаргуулахаар албан бичиг төлөвлөж сум, байгууллагуудад хүргүүллээ.

Архивын баримтаас иргэдийн хүсэлтийн дагуу 97 иргэнд мал тооллогын болон цалин, тушаалын лавлагаа олгон Төрийн архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний үнийн тарифын дагуу 851500 төгрөгийн хураамжийг төрийн сангийн дансанд шилжүүлж иргэдэд үйлчиллээ.

Шарга сумын Говийн хөгжил нэгдэл, Цогт сумын Давшилт нэгдлийн зөвлөлийн 21 хадгаламжийн нэгжийн 4209 хуудас баримтыг скайнердаж, Шарга сумын Говийн хөгжил нэгдэл, Цогт сумын Давшилт нэгдлийн 20 хадгаламжийн нэгжийн 3918 хуудас баримтыг photoshop программаар засварлалаа. Цогт сумын Давшилт нэгдлийн зөвлөлийн 859 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүллээ.

Шарга сумын Говийн хөгжил нэгдлийн 10 хадгаламжийн нэгжийн хавтас сольж, үдэж хавтаслан тавиурт байрлууллаа. Цогт сумын Давшилт нэгдлийн 1980 оны 2 хадгаламжийн нэгжийн хавтас сольж, үдэж хавтаслан тавиурт байрлууллаа. Дэлгэр сумын 1970 оны иргэний үнэмлэх олголтын баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, сэлбэн засалтын ажил хийлээ.

Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад архивын урьдчилсан үзлэгийн хуваарийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлууллаа. Үзлэгийг 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн зохион байгуулна.

Цагдаагийн газрын хурлын зааланд проектор, самбар байрлуулан сургалт явуулах боломжийг хангаж сургалтанд ашиглаж байгаа бөгөөд сургалтын хөтөлбөр 12, сургалтын төлөвлөгөө 1 боловсруулан батлуулж, сургалтын аудио, видео бичлэг 1, сургалтын лекц 12-г боловсруулж, тест бодлого 2-ыг боловсруулан сургалт зохион байгуулж, сургалтад 632,7 мянган төгрөг зарцууллаа.

Алба хаагчдаас Хууль сахиулах их сургуулийн магистрын сургалтад 2, цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд мэргэшүүлэх болон модулын сургалтанд 16, цагдаагийн ерөнхий газарт 1, эрүүгийн цагдаагийн албанд 2 нийт 19 алба хаагч хамрагдав.

Алба хаагчдын сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, ажилдаа хандах хандлага, ёс зүй, зан төлөвд эерэгээр нөлөөлж “Зөв хэвшил, хандлага”-ыг бий болгох

зорилгоор тус газрын сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Гоомарал “Гэр бүлийн харилцааны сэтгэл зүй”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай ойлголт” сэдвүүдээр 2 цагийн сургалт хийлээ.

Зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, баруун бүсийн хамтарсан “Хамтдаа” зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу 2019.01.04-ний өдөр “Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл” байгуулах саналыг хүргүүлсэний дагуу 2019.01.10-ны өдөр Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлын 01 тогтоолоор Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд 10 хүний бүрэлдэхүүнтэй “Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл”-ийг байгууллаа.

Цагдаагийн газраас Дэд зөвлөлийн ажиллах журам, 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлангийн хугацаанд:

Тус зөвлөлөөс орон нутгийн замд үйлдэгдэж буй осол, хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр замын цагдаагийн явуулын пост ажиллуулах, олон нийтийн цагдаа нарыг ажиллуулах, согтуурал тандагч багажтай болох зэрэг саналуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласнаар 6 ширхэг согтуурал тандагч багаж, явуулын постын автомашины зардалд 15.000.000 төгрөг, 7 олон нийтийн цагдааг томилон ажиллуулах урамшууллын асуудлыг тус тус шийдвэрлүүллээ.

Мөн 2018 онд шинээр баригдсан Есөнбулаг, Дэлгэр сумдын замын хяналтын постын гэрэлтүүлгийг бүрэн хийлгэсэн. “Шинэ-Алтай” захын замын хөдөлгөөний эрчмийг бууруулах зорилгоор замын урсгал чиглэлийг өөрчлөх тухай саналыг гаргаж, Есөнбулаг сумын засаг даргад албан бичгээр хүргүүлэн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Есөнбулаг сумын засаг даргаар А/63 дугаартай захирамжийг гаргуулан, шинээр байрлуулах замын тэмдгүүдийг бэлтгэж суурилуулах асуудлыг шийдвэрлээ.

Аймгийн Цагдаагийн газар хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх Шуурхай багийн 2019 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Цагдаагийн газар дээр Шуурхай багийн ажиллах өрөөг гаргаж, өрөөний засвар, тохижилт хийх шаардлагатай санхүүгийн тооцоог хийж, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газарт хүргүүлсэн бөгөөд 18,0 сая төгрөг шийдвэрлүүллээ.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 45 алба хаагч ажиллаж, гарал үүслийн гэрчилчилгээгүй малын мах тээвэрлэсэн, худалдсан 3 зөрчил илрүүлэн 7 хүнд 1050.000 торгуулийн арга хэмжээ авсан. “Шинэ-Алтай” худалдаа үйлчилгээний нэгдсэн зах, мал, малын гаралтай түүхий эд худалдаж, борлуулдаг 7 түүхий эдийн цэгт гадна, дотор орчинг камержуулах талаар мэдэгдэл хүргүүлэн биелэлтэнд хяналт тавин ажиллаж, 7 цэг хяналтын камерт холбогдоод байна.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ЧИГЛЭЛЭЭР  
АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

2019 онд аймгийн нийт төсвийн 12.7 хувийг, орон нутгийн төсвийн 29.6 хувийг орон нутгийн төсвийн орлогоор бүрдүүлж 7664.3 сая төгрөг төвлөрүүлэхээр

батлагдсанаас 90.6 хувийг татварын, 9.0 хувийг татварын бус, 0.4 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Эхний 5 сарын гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 2026.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 2355.6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 329.5 сая төгрөгөөр буюу 16.3 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 386.9 сая төгрөгөөр буюу 19.7 хувиар нэмэгдсэн бол улсын төвлөрсөн төсөвт 400.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 750.3 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 336.0 сая төгрөгөөр буюу 87.3 хувиар давуулан биелүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 193.4 сая төгрөгөөр буюу 34.7 хувиар тус тус өссөн үзүүлэлт болжээ.

Аймгийн хэмжээнд сумдад 355, аймгийн төвд 411 нийт 766 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

### АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Аймгийн төсвийн нийт зарлага 2019 онд 60,2 тэрбум төгрөг батлагдсан. Эхний 05 сарын гүйцэтгэлээр 35.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 28.6 тэрбум төгрөгийн буюу 80.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт төсвийн 19.4 хувийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 53.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээр 10,3 хувийг орон нутгийн хөгжлийн сангийн сангаар, 16,4 хувийг орон нутгийн төсвийн орлогоороо тус тус бүрдүүлж байна.

Улсын төсвөөс орон нутагт 6.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 22,3 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 2.5 тэрбум төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн санхүүжилтийг тус тус авахаар батлагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын төв 17 ширхэг цамхагт гэрэл байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Эс эм жи ти" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Бигэр сумын 5-р багт хөв байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар санхүүжилт нь хийгдэх Аймгийн Цагдаагийн газарт 2 ширхэг суудлын автомашин нийлүүлэх **барааны** гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт нэг ч оролцогч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн замын сангийн хөрөнгийн эх үүсвэрүүдээс санхүүжилт нь хийгдэх Алтай хотод хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Бумбат даваа" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжилт нь хийгдэх Бигэр сумын сум дундын эмнэлэгт шүдний тоног

төхөөрөмж нийлүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер "ДЕС" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Засаг даргын Тамгын газрын барилга /Говь-Алтай, Алтай сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Дэлгэр сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах аргаарын шугамын ажилд дэмжлэг үзүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын 5км газарт 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Эрдэнэ суманд спорт заалны барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Говь-Алтай, Алтай сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай суманд Спорт заалны барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Халиун сумын тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүлэв.

Гамшгаас хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Онцгой байдлын газарт шуурхай албаны автомашин нийлүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Цогт сумын Ээж хөшөөнд дэмжлэг үзүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Жаргалан сумын төвлөрсөн халаалтын зуухны цахилгааны эх үүсвэрийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт үнэлгээний шатандаа байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Орон нутгийн өмчийн 2018 оны хөрөнгийн дахин үнэлгээ болон өмчийн дүн, хөрөнгө актлах, данснаас хасах, хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх, худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай асуудлуудыг шийдвэрүүллээ.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн төв, сумдын санхүүгийн ажилтнуудад зохион байгуулсан сургалтад өмч болон худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтнүүд чиглэлийн дагуу мэдээлэл хийлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Жаргалан сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Гуулин-Эрдэнэ" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжилт нь хийгдэх Гэгээн нуурын загасны нөөцийг тогтоох, ашиглалт явуулах судалгааны ажил хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Эко үйлчилгээ" ТББ шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын гудамж талбай, гэр хороололд хогийн пункер хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Спорт заалын барилга /Говь-Алтай, Бигэр сум/ барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Төгрөг сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах аргаарын шугамын ажилд дэмжлэг үзүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Малын эмнэлгийн лабораторийн багаж тоног төхөөрөмж худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх, хөрөнгө акталж данснаас хасахыг зөвшөөрөх тухай, нээлттэй дуудлагын худалдаа зохион байгуулах тухай асуудлуудыг шийдвэрүүллээ.

Нээлттэй дуудлагын худалдааг аймгийн ИТХ-ын 2019 оны 23, 24-р тогтоолын дагуу 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зарлаж 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Уг дуудлагын худалдаа нь нэг ч оролцогчгүй байсан тул хүчингүй боллоо.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан ажлын хэсэг хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа.



## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

### **Мал үржлийн ажлын чиглэлээр:**

Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 8.6. дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-120 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А-115 дугаар тушаалыг тус тус үндэслэн малд үзлэг ангилалт хийх тухай аймгийн Засаг даргын А/179 дугаар захирамжийг гарган ангилалт хийгдэх Бугат, Цээл, Төгрөг, Халиун, Шарга сумдад хүргүүлж, үүрэг чиглэл өгч хамтран ажиллалаа. Мал сүрэгт үзлэг ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж буюу Шарга сумын “Үржил Алтай” ХХК, Есөнбулаг сумын “Торгон сүрэг” ХХК -уудтай гэрээ байгуулан технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгууллаа. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж нь аймаг, сумдын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран Бугат сумд үржүүлж буй Говь-Алтай үүлдрийн 10.0 мянган толгой хонь, Төгрөг, Халиун, Шарга сумдад үржүүлж буй Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн 3.0 мянган толгой тэмээ, Цээл, Төгрөг сумдад үржүүлж байгаа нутгийн 11.1 мянган толгой ямаа нийт 24.1 мянган толгой малд хаврын үзлэг ангилалтын ажлыг 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хийж гүйцэтгэлээ.

Хаврын үзлэг ангилалтаар шилмэл ангийн шаардлага хангасан цөм сүргийн Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн 450 толгой тэмээ, Говь-Алтай үүлдрийн 3250 хонь, нутгийн улаан 2003 ямаа нийт 5703 толгой малыг ээмэгжүүлэн, бүртгэлжүүллээ.

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсээр 1570.1 мянган хээлтэгч мал тоологдсон. Нийт хээлтэгчийн 82 хувь буюу 1287.6 мянган толгой мал төллөхөөс 1126.5 мянган толгой эх мал төллөж, мал төллөлт 87.4 хувь, 1113.4 мянган төл бойжиж, төл бойжилт 98.8 хувьтай байна.

Нийт гарсан төлийн 2.4 хувь буюу 21.5 мянган толгой төл мал хорогдсон. Зүй бусаар 31.3 мянган толгой том мал хорогдсон байна. Мөн 64.2 мянган толгой эх мал хээл хаясан мэдээтэй байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цогт, Есөнбулаг, Тайшир, Эрдэнэ сумдад инженерийн хийцтэй худаг гаргах ажлыг гүйцэтгэх худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Сойл инжинеринг” ХХК шалгаран гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 09 дүгээр хурал 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хуралдаж Хөхморьт, Баян-уул, Жаргалан, Тайшир, Эрдэнэ сумдад инженерийн хийцтэй худаг гаргах зардлыг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх ээр шийдвэрлэлээ. Есөнбулаг сумын Рашаант багийн нутагт 10,000 га газарт огтоно устгалын ажил хийгдэж байна.

### **Газар тариалангийн чиглэлээр:**

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2019 оны хаврын тариалалтад ашиглах техникийн бэлэн байдлын мэдээ, үрийн нөөцийн судалгааг гаргаж хүргүүллээ.

ХХААХҮ-ийн яамны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих санд бэсрэг алим, чавга, чацарганы суулгацын захиалга ирүүлсэн иргэдэд суулгацыг гэрээ хийн олгосон. ХХААХҮ-ийн яамнаас нарийн ногооны үр татан авч сумдад захиалгын дагуу олгож байна. 2019 оны 05 сарын 31-ны байдлаар нийт 494 га-д тариалалт хийсэн байна. Үүнд: Үр тариа 41.8 га-д, төмс 35.8 га-д, хүнсний ногоо 23.4 га-д, ногоон тэжээл 374.8 га-д, жимс, жимсгэнэ 18.2 га-д тус тус тариалсан байна.

### **Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний ажлын чиглэлээр:**

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилт, үр дүнгийн байдалд улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг сумдад томилогдон ажиллаж улсын үзлэгийн тайлан мэдээг нэгтгэн Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ. Улсын үзлэгээр аймаг 72,28%-иар үнэлэгдлээ.

ХХААХҮ-н Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний А-119 тоот тушаалаар батлагдсан “ЖДҮХС-гаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу иргэд, аж ахуйн нэгжүүдээс төслийг 6 сарын 10 хүртэл ХХАА-н газар хүлээн авч байна.

Ноолуурын үзэсгэлэн худалдааг Дарив суманд зохион байгуулж, “Хан богд кашмери ХХК, Говь-Алтай аймгийн Хөдөө аж ахуйн бирж, сумын иргэд, удирдлагууд оролцлоо. Ноолуурын чанараас хамааран 93,000-95,000 төгрөгөөр худалдан авч, 4.5тн ноолуурын борлуулалт хийлээ

2019 оны 05 сарын 29-31-ны өдрүүдэд Эрдэнэ суманд ноолуурын төвлөрсөн худалдаа зохион байгуулагдаж байна. 11 аж ахуйн нэгж оролцож цагаан ноолуурыг 108,000 төгрөг, өнгийн ноолуурыг 92,000 төгрөгөөр худалдан авлаа.

Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгчидэд тохиролын гэрчилгээ олгох баталгаажуулалтын зөвлөл хуралдаж 10 иргэн аж ахуйн нэгжид 1 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэлээ.

Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа хөнгөн, хүнс, ахуйн үйлчилгээ, нийтийн хоол, худалдааны газрын судалгааг авч нэгтгэж байна.

### **Сургалт сурталчилгаа, зөвлөгөөний талаар:**

Төгрөг сумд зохион байгуулагдсан “Орон нутгийн хөгжилд бидний оролцоо” сэдэвт малчдын зөвлөгөөнд мал аж ахуйн албаны дарга Б.Сарантуяа оролцож “Малын генетик нөөцийн тухай” хууль болон Мал аж ахуйн өнөөгийн байдал цаашдын зорилт үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн. Зөвлөгөөнд Төгрөг сумын 5 багийн нийт 120 малчин оролцсон байна.

Улсын Их Хурал, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, Малын эрүүл мэнд төсөлтэй хамтран “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлэг 5 сарын 07-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдаж аймгийн ИТХ-ын дарга, ХХАА-н газрын дарга, 18 сумын 35 малчин нийт 37 хүн оролцлоо.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт зохион байгуулагдсан хуванцар савны тэмдэг тэмдэглэгээ, органик хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгын талаарх цахим сургалтад хүнсний үйлдвэр, нийтийн хоол хариуцсан мэргэжилтэн хамрагдлаа.

ХХААХҮ-ийн яам, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран зохион байгуулсан МАА-н салбарын жендерийн дүн шинжилгээ сэдэвт сургалтад тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн хамрагдаж салбарт мөрдөгдөж буй жендерийн бодлогын баримт бичигтэй танилцаж, мал аж ахуйн жендерийн дүн шинжилгээ хийх арга зүйд суралцлаа.

ХХААХҮ-ийн яамнаас Ховд аймагт зохион байгуулж буй Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмын танилцуулга, төсөл хүлээн авах, сонгон шалгаруулалт хийх журмын хэрэгжилтийг хангах, аймаг орон нутагт байгуулагдах дэд хорооны гишүүдэд мэргэжил арга зүйгээр хангах сургалтад холбогдох албан тушаалтнууд хамрагдлаа.

Мал эмнэлгийн газрын лабораторид Тайшир, Дэлгэр, Чандмань сумдаар шүлхий өвчний болон бог малын мялзан өвчний тандалт шижилгээг 05 сарын 27- 06 сарын 5-ны өдрүүдэд хийлээ.

Говь-Алтай аймгийн адууны үүлдэр угсаа сайжруулах зорилгоор зүүн бүсээс ирсэн 33 толгой эрлийз азарган үрээнд нийлүүлгийн өвчний шижилгээ хийхэд 4 адуу эерэг урвалтай илэрсэнд холбогдох арга хэмжээг авах талаар тус сумдад хариу хүргүүлээ.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа цайны ба зоогийн газар, рестораны 17272 кг махны 167 дээж, 1155 ш өндөгний 11 дээжинд МЭАЦ-ийн магадлан шинжилгээ хийж, 690 ш хонины нэхий, 2 толгой адуунд гарал үүслийн гэрчилгээг тус тус олголоо.

“Ногоон алт –Малын эрүүл мэнд” төслөөс Дэлгэр, Чандмань сумыг бэлчээр зохион байгуулалт, малын гоц халдварт өвчингүй загвар сумаар шалгаруулж Мал эмнэлгийн баталгаажуулалтын шинэ системийн эхний шатны сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн Мал эмнэлгийн газар, Эрдэнэ, Чандмань, Бигэр, Дарив, Дэлгэр, Тайшир, Хөхморьт, Халиун, Баян- Уул сумдын мал эмнэлгийн тасгийн 18 малын эмч оролцлоо.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх вакцинд 848,6 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 83.4 хувьтай байна.

Халдварт паразиттах өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1895.0 мян.толгой мал хамрагдахаас туулгалтад 789.5 мянган толгой мал, боловсруулалтад 195.4 мянган толгой мал, угаалгад 55.6 мянган толгой мал нийт 1040.5 мянган толгой малыг хамруулж тус ажил 52,2 хувьтай хэрэгжиж байна.

#### ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

*Хот байгуулалт, барилга байгууламжийн чиглэлээр:*

Бигэр сумын төвд жишиг гудамж, тохижилтын ажлыг “Өнө-Алтай” ХХК гүйцэтгэсэн хүлээж авах комисс томилсон бөгөөд комиссын шийдвэрээр байнгын ашиглалтад оруулаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Солонго хорооллын дулааны станцын өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулах улсын комиссыг томиллоо. 2019 оны 06 сарын 30-нд улсын комисс ажиллана.

Бүгд Найрамдах Солонгос Улсын “Экспорт-Импорт” банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн төслийн хүрээнд баригдах 25 Гкал/цаг хүчин чадалтай дулааны станц, ус дулаан дамжуулах 6 төвийн ус, дулаан дамжуулах төвүүдийг ус хангамж хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох техникийн нөхцөлийг хүргүүлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарсан ажлуудын барилга угсралтын ажлыг ойрын хугацаанд эхлүүлэх талаар үүрэг чиглэл өглөө.

Улсын хөрөнгөөр баригдаж байгаа Дарив сумын 320 хүүхдийн сургуулийн өргөтгөл, Номын сангийн барилгуудад бетоны маркийг үл эвдэх аргаар тодорхойлон шинжилгээний хариуг гүйцэтгэгч “Цахир толгойн орд” ХХК, “Рок пэинт групп” ХХ компаниудад хүргүүлээ. Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг улсын болон хувийн хөрөгө оруулалтаар баригдаж байгаа 5 барилга, байгууламжид олголоо.

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 сарын 24-ний өдрийн А/318 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр Алтай хотын Солонго хороололд ашиглалтад орсон 120 айлын орон сууцыг Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын дагуу иргэдэд өмчлүүлэх, мөн худалдан борлуулах талаар иргэдээс судалгаа авч нэгтгэх ажил хийгдэж байна.

#### ***Газар зохион байгуулалтын чиглэлээр:***

Газрын төлбөрийн орлогыг 5764,0 мянган төгрөг төвлөрүүллээ.

Газрын кадастрын зураг 35 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад гаргаж өгч үйлчиллээ.

Газар эзэмших эрхийн гэрчилгээ 20 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олголоо.

#### ***Нийтийн аж ахуйн чиглэлээр:***

1. 2019 оны 06-р сард “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа 3 гүний худаг, 2 нөөцийн худагтайгаар үйл ажиллагаагаа явуулж Алтай хотын ард иргэддээ 48728 м3 ус олзворлолоо.

2. Даралтат усан сан нь 2-р өргөлтийн насос станцын шахсан усыг 100% хүлээн авч хотруу шахсан бол цэвэрлэх байгууламж нь 2019 оны 06-р сард 42039 м3 бохир усыг өөрийн картандаа хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд 6,3м3 усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаясан байна.

3. “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ нь 06-р сарын 03,19-ны өдөр техникийн нөхцөл олгох комиссын 07,08 тоот протоколуудыг үндэслэн шинээр баригдах 20 айлын орон сууцны барилга, 2 албан газар, 1 аж ахуйн нэгж, шинээр төлөвлөгдөж байгаа дулааны станцын 6 ширхэг дулаан лахин дамжуулах төвийн барилгад цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбох 622,2 м3 цэвэр усны хоногийн хэрэглээ, 90,7 м3 бохир усны хоногийн хэрэглээ бүхий техникийн нөхцлийг олгосон байна.

#### **ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Бигэр сумын Сум дундын эмнэлэг, Бигэр шимт элс, Наран элс бөөрний сувиллын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ, ажлын байрны хяналт, үнэлгээ хийлээ.

Хүүхдийн зуны амралт эхэлж байгаатай холбогдуулан өвчлөл, осол гэмтлээс сэргийлэх, эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулах чиглэлээр орон нутгийн телевизээр мэдээлэл хийлээ.

Эрүүл мэндийн байгууллагуудын дунд бүсийн ажил мэргэжлийн уралдааныг зохион байгуулахаар 3 бүсэд явж ажиллаа.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулж буй “Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг хамтран зохион байгууллаа.

“Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” өөрийн үнэлгээний гарын авлагын дагуу асуумж судалгааг 19 сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын болон нэгдсэн эмнэлэгээс авч Эрүүл мэндийн яаманд мэйл хаягаар хугацаанд нь хүргүүллээ.

Цаг уур орчны шинжилгээний газрын албан хаагч 19 хүнд “Архины хор хөнөөл” сэдвээр сургалт хийлээ.

Эрүүл мэндийн яамнаас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд Эрүүл мэндийн газрын Статистик бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Ш. Майнбаяр, Нэгдсэн эмнэлгийн сүлжээний инженер Б. Хаш-Эрдэнэ нар “Компьютер хэрэглэгчдийн сургалтын сургагч багш бэлтгэх” сургалтанд 3 хоног хамрагдаж сургагч багшийн эрх авлаа.

Тархвар судлалын 25-р 7 хоногийн байдлаар хачигт халдвар 7, гэдэсний халдвар 3, нийт 10 тохиолдол бүртгэж ХӨСҮТ-д EWAR-аар мэдээллээ.

Тэмбүүгийн оношлогоо, эмчилгээ түргэвчилсэн оношлуурын талаарх мэдээлэл цахим сургалтад хамрагдлаа.

“Инээмсэглэл эерэг хандлага” бүсийн зөвлөлдөх уулзалтыг Цээл, Шарга, Тайшир сумдад 2019 оны 06 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд зохион байгуулж 18 сумдын эрүүл мэндийн төвийн 321 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж сургалт, ажил мэргэжил, урлаг спортын тэмцээнийг зохион байгууллаа. Мөн “Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдахын ач холбогдол”, Артерийн даралт ихсэлт цус харвалтаас сэргийлэх” сэдвүүдээр 87 иргэдэд эрүүл мэндийн сургалтыг зохион байгууллаа.

### ДОЛОО. БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлдэг “Бага боловсролын сургалтын чанарыг сайжруулах” зорилготой сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх IV шатны төслийг 5 чиглэлээр зарлаж 27 сургуулийн 61 төслийг БСШУСЯ-нд хүргүүлснээс 20 төсөл шалгарч - 356.3 сая төгрөгийн санхүүжилт Алтай нутгийн бага боловсролын багш, сурагч, сургалтын менежерүүдийг хөгжүүлэхэд зориулагдахаар батлагдсан байна. БСШУСЯ-ны сайдын А/284 дүгээр тушаалын дагуу төсөл нь шалгарсан сургуулийн захирлуудтай Боловсрол, соёл урлагийн газрын дарга гэрээ байгууллаа.

STEM сургалтын хэрэгжилт үр дүнд анализ хийх зорилгоор БСШУСЯ-ны мэргэжилтэн Р.Балжиннямын хамт 4 сургууль дээр мониторинг хийлээ. Бага боловсролын STEM хичээлд ажиглалт, хэлэлцүүлэг хийх замаар сургалтын үр дүн, суралцагчийн хөгжил төлөвшилд гарч буй ахиц, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх, багш нарт арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор нийт 4 багшийн хичээлд ажиглалт хийж 60 багшид арга зүйн зөвлөгөө өглөө.

Мөн бага ангийн сургалтын хөтөлбөрт хэрэгжүүлж буй STEM сургалтыг зохион байгуулахад багш, сурагчдад тулгамдаж буй асуудал, давуу талыг илрүүлэх зорилгоор нийт 60 сурагч, 60 багштай бүлгийн ярилцлага зохион байгуулж нэгдсэн дүгнэлтийг гарган ажиллалаа.

Улсын шалгалтын зохион байгуулах болон сэдэв даалгавар боловсруулах арга аргачлалыг Боловсролын үнэлгээний төвөөс хүлээн авч мэдээллийг бүх сургуулиудад хүргүүлсэн. Шалгалтын сэдвийг боловсруулах эрхийг сургалтын менежерүүдэд хүргүүлэн зааварын дагуу боловсруулж, шалгалт авч, мэдээллийг 24 цагийн дотор БСМС-д оруулан баталгаажуулж ажиллалаа.

Боловсролын түвшин	Шалгалтын агуулга	Анги	Шалгалтын өдөр, хугацаа			
			Өдөр	Эхлэх цаг	Дуусах цаг	Шалгалт үргэлжлэх хугацаа
Бага	Монгол хэл	5	2019 оны 05 дугаар сарын 27	10:00	11:00	60 минут
	Математик	5	2019 оны 05 дугаар сарын 29	10:00	11:00	
	Хүн ба байгаль	5	2019 оны 05 дугаар сарын 31	10:00	11:00	
Суурь	Монгол хэл	9	2019 оны 05 дугаар сарын 28	10:00	11:20	80 минут
	Математик	9	2019 оны 05 дугаар сарын 30	10:00	11:20	
	Сонгох шалгалт (байгалийн ухаан, нийгмийн ухаан)	9	2019 оны 06 дугаар сарын 03	10:00	11:20	
	Гадаад хэл (англи хэл, орос хэл)	9	2019 оны 06 дугаар сарын 05	10:00	11:20	
Бүрэн дунд	Монгол хэл	12	2019 оны 05 дугаар сарын 29	10:00	11:20	80 минут
	Математик	12	2019 оны 05 дугаар сарын 31	10:00	11:20	
	Сонгох шалгалт (хими, физик, биологи, нийгэм, түүх, газарзүй)	12	2019 оны 06 дугаар сарын 04	10:00	11:20	
	Гадаад хэл (англи хэл, орос хэл)	12	2019 оны 06 дугаар сарын 06	10:00	11:20	

Дүн мэдээ:

Анги	Шалгалт	Бүлгийн тоо	Суралцагчийн тоо	Ирсэн	Тасалсан	Чөлөөтэй	VIII	VII	VI	V	IV	III	II	I
5	Монгол хэл	55	114 7	113 7	9	1	41 9	27 8	176	21 2	22	26	3	2
	Математик	55	114 7	113 7	9	1	30 9	25 5	226	28 7	11	21	19	10
	Б/У,	55	114	113	9	2	45	26	209	17	16	11	2	1

	НАБ, Б/Б		7	6			2	9		8					
9	Монгол хэл	56	931	905	25	1	33	25	158	14	6	10	2	0	1
	Математик	56	931	905	25	1	24	21	188	20	6	24	16	14	3
	Гадаад хэл	56	931	904	26	1	25	23	181	22	6	5	3	1	1
	Сонгосон хичээл	56	931	906	25	0	29	27	171	17	0	1	0	0	0
12	Монгол хэл	39	617	566	48	3	27	14	74	71	4	0	0	0	0
	Математик	39	617	567	48	2	19	15	104	10	7	3	1	0	0
	Гадаад хэл	39	617	564	52	1	19	16	92	10	0	7	0	0	8
	Сонгосон хичээл	39	617	569	48	0	23	17	97	55	1	0	0	0	5

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, яамны газар, хэлтсийн дарга, удирдлагуудтай 2019 оны 06 сарын 06-ны өдрийн 10:00 цагаас 14:30 цагийн хооронд цахим хурал хийлээ.

Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх дэд төслийн 2 шатны "Олон нийтийн оролцоот сургууль" дэд төслийн сургагч багш нарыг бэлтгэх сургалтад 20 хүн хамрагдсан. Төслийн хэрэгжилтийн багийн сургагч багш нар Алтай, Цогт, Цээл, Халиун сумдын сургуулийн 30 хүнд "Олон нийтийн оролцоот сургууль"-ийн сургалт болон төслийн хэрэгжилтийн талаар 2019 оны 06 сарын 09-11-ний өдрүүдэд сургалт зохион байгууллаа.

2019 оны 06 сарын 08-нд Монгол Улсын гавьяат багш Р.Бавуудорж багш Алтай нутагтаа ирж Физикийн багш нарт ЭЕШ-ын талаар зөвлөгөө, сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 20 багш хамрагдлаа.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2019 оны 06 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Шалгалтад 17 хичээлээр 513 хүүхэд орсон байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын комисст 22 хянагч багш, 6 зохион байгуулагч багшид хэрхэн ажиллах, анхаарах зүйлийн талаар сургалт хийлээ.

Шалгалтын нэр	Бүртгүүлсэн	Шалгалтад орсон	Ирээгүй	Ирц /хувь/	Ажилласан хянагч багшийн тоо
Монгол улсын түүх	16	15	1	93.8	4

Физик	156	148	8	94.8	12
Хими	146	139	7	95.2	10
Газарзүй	13	10	3	76.9	2
Англи хэл	291	284	7	97.6	18
Биологи	152	142	10	93.4	10
Математик	344	316	28	91.9	20
Монгол хэл	359	334	25	93.0	22
Орос хэл	5	4	1	80.0	2
Нийгэм	341	313	28	91,7	20
<b>БҮГД</b>	<b>1823</b>	<b>1705</b>	<b>118</b>	<b>90,8</b>	<b>120</b>

НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛ,  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр настан-53, тахир дутуу-33.

Нийт 86 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Сайн дурын даатгалд-37, Эрүүл мэндийн даатгалд-427 иргэнийг шинээр даатгалд хамруулж, 20562.4 мянган төгрөг төвлөрүүлээ.

Хөдөлмөрийн чадвар түр алдсан-70 хүнд 10597.8 мянган төгрөг, Жирэмсэн, амаржсан 56 хүнд 71951.5 мянган төгрөг, Оршуулгын-27 хүнд 27,0 сая төгрөг тогтоолгож, олголтыг хийлээ.

Ажилгүйдлийн тэтгэмж шинээр 20 хүн тогтоолгож, 21785.5 мянган төгрөг олгогдсон байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 210 хүн орж, шинээр 34 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 6 хүн цуцлагдаж 189 хүн сунгагдлаа.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 54 хүнд олгосон байна.

Нийт 714 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба 354 нь эмэгтэй байна. Тайлант сард аймгийн хэмжээнд 11 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авлаа. Мөн 14 аж ахуй нэгж байгууллагаас 118 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирсэн байна. Үүнд:

- Марка Поло хайгуулын компани тогоочийн ажлын байрын захиалга ирснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд түгээв. Анар-Дент шүдний



эмнэлэгнүүр амны ерөнхий мэргэжлийн болон согог гажиг засал, эрүү нүүрний мэс заслын нарийн мэргэжлийн эмч-1, сувилагч -1

-Завхан аймгийн Дөрвөлжин сумд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани эрэгтэй эмэгтэй харуул хамгаалалтын ажилтан, англи хэлтэй оператор, жолооч

-Алтай хотын тохижилт үйлчилгээний газарт жолооч-1, ачигч-2 гэсэн ажлын байрын захиалга ирүүлснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд хүргэж зуучлах үйлчилгээ үзүүлэв.

- Нэгдсэн эмнэлэгт жолоочийн орон тоо

- Хаан банкны Говь-Алтай аймаг дахь салбарын харъяа Дарив, Алтай тооцооны төвд теллер, Бугат, Тонхил, Чандмань тооцооны төвүүдэд ажилтан авах захилга тус тус ирээд байна.

### **Нийгмийн халамжийн сангаас дараах тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтийг хийлээ.**

- Халамжийн тэтгэвэр 1258 иргэнд 223,9 сая.төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 832 иргэнд 66,7 сая.төг
- Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 831 иргэнд 76,2 сая.төг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 113 иргэнд 15,0 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 83 иргэнд 4,9 сая.төг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 457 иргэнд 19.8 сая төгрөг
- Алдарт эхийн одонтой 26 эхэд 2.6 сая төгрөг
- Цалинтай эхийн тэтгэмж 2634 иргэнд 128.9 сая төгрөг
- Өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 122 иргэнд 38.5 сая төгрөг
- Насны хишиг 2239 иргэнд 190,0 сая төгрөг
- Алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 5,4 сая.төгрөг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний Бүлгийн төслийг сонгон шалгаруулж 18 сум 2 тосгоноос амьжиргаа дэмжих зөвлөлөөр дэмжигдэж ирсэн 25 төслийг ажлын хэсэг хэлэлцэж шаардлага хангаж байгаа цаашид хэрэгжих болмжтой 23 төсдийг шалгаруулж халамжийн сангаас эхний санхүүжилт болох 21.350.000 төгрөгийн санхүүжилтийг шилжүүллээ.

### ЕС. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хүүхэд-Залуучуудын ордны дугуйлангийн сурагчид болон Есөнбулаг сумын сургууль цэцэрлэгүүдийн 250 гаруй авъяаслаг сурагчид уран бүтээлийн тоглолтоо өргөн барилаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан зорилтод өрхийн болон эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 250 гаруй хүүхэд багачуудаа хүлээн авч гарын бэлэг гардуулан "Би нар" уран сайхны киног Хүүхэд-Залуучуудын Мазаалай театртаа үнэ төлбөргүй үзүүллээ.

Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх, эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгах

чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Зөв тусгал” аянг нэг сарын хугацаанд зохион байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

“Зөв тусгал” аяны төлөвлөгөөний дагуу орон нутагт хийгдэх ажлын салбар төлөвлөгөөг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, Дэлхийн зөн ОНХ-тэй хамтран гаргаж, арга хэмжээнд зарцуулагдах 2535500 төгрөгийн төсвийн тооцооллыг хийн хамтран зохион байгуулах байгууллагуудад хүргүүллээ. Тус арга хэмжээнд 27 төрийн болон төрийн бус байгууллага хамтран ажилласан байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.2.2, 7.3.1, 7.4 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчилдэг 65 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2 удаа хийж, 1 зөрчил илрүүлэн, 1 хүнд 50.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг Цагдаагийн газраас авч 35 аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлэн биелэлтэнд хяналт тавин ажиллалаа.

Хүүхэд хамгаалагч төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж, сонгогдсон хүүхэд хамгаалагч ахмад ажилтан 2 хүнийг чадвахжуулах 4 цагийн сургалтыг Цагдаагийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулж, үйл ажиллагааг эхлүүллээ. Хүүхэд хамгаалагч нараас аяны хугацаанд Есөнбулаг сумын 6 сургуулийн бүс, 4 багийн нутаг дэвсгэрт хүүхдэд зөвлөн туслах, эрсдэл, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж нийт 26 хүүхдэд хүрч ажиллалаа.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран Дэлхийн зөн ОНХ-ийн дэмжлэгтэйгээр ЕБС-ийн сурагчдад “Хүүхэд насыг хайрла, түүнийг хамгаал”, “Цахим орчин зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд 11 сургуулийн 650 сурагчид сургалт мэдээлэл хийж, хүүхэд хамгааллын талаарх зурагт хуудас 300 ширхэгийг тараасан байна.

Аяны хүрээнд эцэг, эхчүүдэд “Эцэг, эхийн үүрэг хариуцлага”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр сургалт мэдээллийг 4 удаа хийн 150 эцэг, эхийг хамруулж 4 төрлийн гарын авлага, зөвлөмж 450 ширхэг, “Иргэн танд хүргэх ил захидал” 30 ширхэгийг тараалаа.

АШУУИС-ийн оюутны зөвлөл, Цагдаагийн газартай хамтран төгсөх ангийн оюутнуудад “Хууль бидний амьдрал” сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан, Зөрчлийн тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудаар мэдээлэл хийж, 78 оюутныг хамрууллаа.

Албан байгууллагуудад эцэг эхчүүдийн гэр бүлийн боловсрол, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдээлэл, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Хот тохижилт үйлчилгээний газрын 46 албан хаагчдад “Хүмүүжлийн эерэг арга & Зөв тусгал” сургалтыг “Хайрлагдсан Алтай” ТББ-тай хамтран зохион байгуулж тусламж дэмжлэг шаардлагатай 20 өрхийн хүүхэд тус бүр 40.000 төгрөгний тусламжийг “Хайрлагдсан Алтай” ТББ-аас үзүүллээ.

Цагдаагийн газраас хууль, дүрэм журмыг энгийн байдлаар иргэдэд ойлгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, шинэ санаа санаачлагыг дэмжих чиглэлээр тасаг, албадын дунд видео, шторк, алба хаагчдын дунд постерын уралдааныг зохион байгуулж, уралдаанд 3 видео, шторк, 26 төрлийн

постер ирүүлснээс эхний 3 байрыг шалгаруулж, цахим хуудсаар сурталчилан түгээлээ.

Арга хэмжээний хүрээнд нийт 13 удаа сургалт зохион байгуулж, 14 байгууллага аж ахуйн нэгжийн 878 хүн хамрагдаж, 3 төрлийн наадаг зурагт хуудас 300, 10 төрлийн 100 ширхэг гарын авлага, зөвлөмж 450 ширхэг, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр “ЗӨВ ТУСГАЛ” өртөөг ажиллуулан “Хүчирхийллийг зогсоож чадна” “Зөв тусгал” аяны сурталчилгааны хичээлийн хуваарь-200, кист-200, наалт-200, Амлалт-300 ширхэгийг тарааж 310 хүүхэд, 250 эцэг эх, аймгийн удирдлага 7, нийт 567 хүнийг аянд нэгдүүллээ.

Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан “Зөв тусгал” аяны хүрээнд “Хүүхэд таныг биш, та хүүхдээ ойлгох ёстой” уриан дор “Аз жаргалтай гэр бүл” хэлэлцүүлгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн ОНХ, Монголын эмэгтэйчүүдийн аймгийн салбар зөвлөлтэй хамтран Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Мазаалай” театрт зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Есөнбулаг сумын 6 сургуулийн сурагчдын эцэг, эхийн төлөөлөл 200 хүн оролцож, сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлж, ярилцан, оролцогчдод “Хүүхдийн аюулгүйн дүрэм” “Хүмүүжлийн эерэг арга”, “Гэрийн дүрэм” гэсэн 4 төрлийн гарын авлагыг тарааж, “Зөв тусгал” аянд нэгдүүлсэн.

Аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөлийн сурагчид, “Сэтгүүлч клуб” сурагчид хамтран хүүхдийн төлөө ажилладаг байгууллагуудын удирдлага, мэргэжилтэн 3 хүнтэй “Гэр бүл, хүүхдийн өмнө тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга зам” шууд ярилцлага, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, цахим хуудсаар иргэд олон нийтэд суртчилан түгээн ажиллалаа.

Аяны хүрээнд “Аз жаргалтай гэр бүл” гэрэл зургийн уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж, нийт 26 бүтээл ирснийг Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр үзэсгэлэн гаргаж, олон нийтэд сурталчилан эхний 1-3 байрт шалгарсан 6 бүтээлийн эздэд шагналыг гардууллаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 3-5 дугаар ангийн сурагчдын дунд “Миний гэр бүл” гар зургийн уралдааныг зохион байгуулж 5 байр шалгаруулан шагнаж урамшууллаа.

Сургуулийн болон гэр бүлийн орчинд үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмүүд харилцан туршлага судлах, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор ЕБС-иудын дунд “Өсвөрийн сэргийлэгч-2019” тэмцээнийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улаан загалмайн хороотой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд Есөнбулаг сумаас 5 сургуулийн баг, Дэлгэр, Бигэр, Дарив, Тайшир, Тонхил сумдын сургуулиас, нийт 10 багийн 100 гишүүн оролцож, удирдамжид заагдсан 6 төрлөөр өрсөлдөж, тэргүүн байрт Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн “Эрдэмт шонхорууд”, Дэд байрт Бигэр сумын сургуулийн “Хүлгүүд”, гутгаар байрт Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 4 дүгээр сургуулийн “Гэрэлт-Ирээдүй”, тусгай байрт 2 дугаар сургуулийн “Шонхор”, 3

дугаар сургуулийн “One family” багууд шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар, амжилттай оролцсон бусад багуудад Өргөмжлөл, гарын авлага хүлээлгэн өглөө.

Эцэг эхчүүдийн хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдлэгийг сайжруулах, гэр бүлд дурсамжтай мөчийг үлдээх зорилгоор “МИНИЙ ГЭР БҮЛ-МИНИЙ ЕРТӨНЦ” өдөрлөгийг зорилтот өрхийн 30 эцэг эх, 30 хүүхдийг хамруулан зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдээллийг өгч, хүүхэд эцэг эхчүүдийн дунд хөгжөөнт тоглоом, “Аав ээж би” , АХА тэмцээнийг Цагдаагийн газар, Дэлхийн зөн ОНХ, Гэрээр айлчлагч нартай хамтран зохион байгуулж тэмцээнд амжилттай оролцсон гэр бүлийг байр эзлүүлэн шагнаж өдөрлөгт оролцсон хүүхэд бүрт хүүхдийн баярын бэлэг гардуулж өглөө.

Аяны хүрээнд зохион байгуулсан ажил, арга хэмжээ, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл, видео шторк, постеруудыг орон нутгийн “Миний нутаг” телевизээр 4 удаа, давтамж 36 удаа, 108 минут, “Алтайн мэдээ” сонинд 1, Цагдаагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Page хуудсаар 9 удаа байршуулан нийт 10461 хүн хандсан байна.

-Аяны хүрээнд ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс ирүүлсэн 2 төрлийн 200 ширхэг зурагт хуудсыг Цагдаагийн газраас олон нийтийн сурталчилгааны самбар, автомашинд байршуулан ажилласан байна.

-Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн Page хуудсанд тавигдсан видео, шторк, постеруудыг 2785062 дагагчтай 50 группуудад тухай бүр нь шэйрлэн түгээж, иргэдэд сурталчилан ажилласан.

Тус арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулснаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мөн эцэг эхийн хийж буй сайн муу үйлдэл бүхэн хүүхдэд нөлөөлдгийг аянд нэгдсэн хүн бүр ойлгож хүүхдийнхээ зөв тусгал нь болохын тулд хүүхдэдээ сайнаар үлгэрлэх, тэднийг сонсож найз шиг нь байх, хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх нь зөв хүн болж төлөвшихөд нь чухал гэж санал нэгдлээ.

Өсвөр насны хөвгүүдийг болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, хорт зуршлаас татгалзан биеэ зөв авч явах ёс суртахууны зөв зан үйлийг төлөвшүүлэхэд нь дэмжих, цахим ертөнцөд учирч болох эрсдэлээс өөрсдийгөө болон найз нөхдийгөө хамгаалах мэдлэг мэдээллээр хангах, тэдний хүмүүжил төлөвшилтийг сайжруулах зорилгоор “Бидний сонголт-Зөв хүн” уриан дор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хамтран “ЭРХЭМ САЙН ХӨВГҮҮН-3” аянг 2018 оны 04 дүгээр сарын 15-наас 05 дугаар сарын 15-ыг хүртэлх хугацаанд зохион байгууллаа. Аянг сургуулийн Нийгмийн ажилтан, сумын Хэсгийн төлөөлөгч, Цагдаа, Биеийн тамирын багш, Газарзүйн багш, Сургуулийн эмч, Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн ахлагч, Дотуур байрын багш гэх мэт бүрэлдэхүүнтэйгээр 21 сум сургуулийн 21784 хүүхэд /15110-эр, 6674-эм/, 4285 иргэд нийт 26069 хүнийг 10 төрлийн үйл ажиллагаанд хамруулан 14435680 төгрөгийн төсөвтэйгээр сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, сумдын ИТХ, сумдын ЗДТГ, Цагдаагийн хэсэг, Эцэг эхийн зөвлөл, Эрүүл мэндийн төв, Ахмадын холбоо, Соёлын төв, Дэлхийн зөн

ОНХ, Ахмад багш нар, Говийн их дархан цаазат газрын захиргаа, Улаан загалмайн хороо, Төрийн бус байгууллагууд, Хүүхдийн оролцооны байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Аянд оролцсон сумдаас Тонхил, Алтай, Дэлгэр, Баян-Уул, Баянтоорой сумууд зохион байгуулсан ажлаараа эхний 5 байрт шалгарлаа.

“Эрхэм сайн хөвгүүн-3” аянг зохион байгуулснаар 2018 оны мөн үетэй харьцуулахад насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн гаралт 33,3%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Орон нутагт амьдран, оршин сууж байгаа 18 хүртэлх насны бүтэн өнчин хүүхдүүдийн бүртгэл, судалгааг шинэчлэн гаргаж, 47 бүтэн өнчин хүүхдийн хадгаламж нээлгэхэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар бүтэн өнчин хүүхэд тус бүрт 100 000 төгрөгийн хадгаламжийг нээж, хүүхдийн баяраар гардуулан өгөхөөр шийдвэрлэлээ

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ээжүүд сэтгэл зүрхээрээ нэгдэж тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрхийг хамгаалах зорилгоор “Ээлтэй хүүхэд” гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллагыг 5 хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулж тэргүүн Ж.Оюунчимэг гэрчилгээгээ гардан авлаа.

Хүүхдийн эрх, хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн дурсамжтай мөчийг үлдээх зорилгоор гэр бүлийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж байгаа 30 эцэг эх, хүүхдийг хамруулан “Миний гэр бүл-Миний ертөнц” өдөрлөгийг зохион байгууллаа.

Автомашин согтуугаар жолоодсон, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэн баривчлагдсан 7 иргэнд хүүхдийн эрх, хамгаалал, гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгууллаа.

Говь-Алтай аймгийн Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн 2019 оны 2 дугаар хуралдаан 2019 оны 06 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдлаа. Хуралдааныг Засаг дарга, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн тэргүүн В.Рэнцэндорж удирдан явууллаа. Хуралдаанаар:

- Аймгийн залуучуудын урлаг спортын наадам зохион байгуулах
- Залуу гэр бүлүүдийг хямд үнэ өртөг бүхий орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх, хөнгөлөлттэй зээлэнд хамруулах журам боловсруулах
- Засаг даргын нэрэмжит тэтгэлгийг жилд 5-аас доошгүй залуучуудад үзүүлэх
- Залуучуудын сарын аян зохион байгуулах
- Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн хагас жилийн ажлын тайлан зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, эцэг эхчүүдийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж сургалтад 500 хүн хамрагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2019-2020 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,

хэлтсийн албан хаагчдын хамтын ажиллагааг сайжруулах, ажлын уялдаа холбоог нэмэгдүүлэх, салбарын хууль тогтоомжийг сурталчлах, хүүхдийн эрхийн конвенцын үзэл санааг таниулах, хүүхэд хамгааллын чиглэлээр нэгдсэн зөвлөгөөнийг Улаанбаатар хотод 2019 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд зохион байгуулж салбарын албан хаагчид хамрагдлаа. Зөвлөгөөний үеэр салбарын албан хаагчдын дунд конвенц-30 спортын наадмыг 6 төрлөөр зохион байгуулж тус газраас бөхийн барилдаанд түрүүлж, билльярдаар алтан медаль авлаа.

Гэртээ хүүхдээ хардаг бүсгүйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой "Залуу эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр" 2019/04/01 ний өдөр эхэлж, 2 сарын туршид сургалтанд хамрагдаж 6 сарын 1-ний энэ өдөр сертификатаа гардан авлаа.

### АРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Дэлхийн байгаль орчны өдрийн хүрээнд аймгийн Шүүх, УЦУОШТ-тэй хамтран харилцан мэдээлэл солилцох арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд байгаль хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээллийг оролцогчдод хүргэж, танин мэдэхүйн АХА тэмцээн зохион байгууллаа. Дэлхийн байгаль орчны өдрийг анх 1972 онд НҮБ-ын Ерөнхий чуулганаас жил бүрийн 06 дугаар сарын 05-ны өдрийг "Дэлхийн байгаль хамгаалах өдөр" болгон тэмдэглэж байхаар тунхагласан билээ. Энэ өдрийг тохиолдуулан НҮБ-ын гишүүн орнууд байгаль орчны тулгамдсан асуудлуудад бодлого боловсруулагчид болон олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор нийтэд зориулан төрөл бүрийн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулан ирсэн бөгөөд байгаль орчинд ээлтэй үйлс хийхэд дэлхий нийтийг чиглүүлдэг хамгийн олон хүнийг хамарсан онцгой өдөр юм. Тус өдрийг энэ жил дэлхий нийтээр ["Агаарын](#) бохирдлын эсрэг хамтдаа" гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг 21 аймагт үнэ төлбөргүй мэргэжлийн багш нар зохион байгуулж байгаа бөгөөд тус аймагт 2019 оны 06 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж 18 сум 2 тосгоноос нийт 110 гаруй хүн 10 мэргэжлээр онол, практикийн сургалтад хамрагдаж мэргэжлийн сертификаттай боллоо.

БОАЖЯ-ны Сав газрын удирдлагын хэлтэс, "20-30 усны нөөцийн бүлэг", Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ, Буйр нуур-Мэнэнгийн тал сав газрын захиргаанаас "Зүүн бүсийн сав газрын захиргаа болон талуудын оролцооны зөвлөлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх анхдугаар зөвлөгөөн"-ийг Дорнод аймагт 2019 оны 06 дугаар сарын 02-08-нд, мөн дээрх байгууллагууд болон Хүйсийн говь-цэцэг нуурын сав газрын захиргаанаас "Баруун бүсийн сав газрын захиргаа болон талуудын оролцооны зөвлөлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх анхдугаар зөвлөгөөн"-ийг Говь-Алтай аймагт 2019 оны 06 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд тус тус зохион байгууллаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 оны 06 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд "Уул уурхайн салбарын баруун бүсийн нээлттэй хаалганы өдөрлөг" арга хэмжээ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам ТНС төсөлтэй хамтран "Сутай хайрхан уул" байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах



уулзалт, хэлэлцүүлэгийг 2019 оны 06 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Ховд аймагт тус тус зохион байгуулагдах бөгөөд бэлтгэл ханган ажиллаж байна.

Ус ашиглалттай холбоотой гаргасан дүгнэлт, олгосон зөвшөөрөл, хэмнэлт, эргүүлэн болон дахин ашиглалт, булаг шандны эхийг хашиж хамгаалах, нөхөн сэргээх, хөв цөөрөм байгуулан усны нөөцийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр төлөвлөн зохион байгуулсан ажлын хэрэгжилт, явцын мэдээг 2019 оны хагас жилийн байдлаар гарган БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлээ.

Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд 2019 оны хагас жилийн байдлаар тус газраас гаргасан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ дүгнэлтүүд болон батлагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний талаарх судалгаа, тайланг тус тус гарган БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэст хүргүүлэв.

Тус газраас БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, итгэмжлэгдсэн лабораторийн болон бусад төлөөлөлтэй хамтарсан баг бүрэлдэхүүнийг холбогдох багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй нь тус аймагт ажиллуулж аммиакийн хөргөлттэй махны зоорь, баяжуулах тээрмүүд, мөнгөн ус хэрэглэсэн байх магадлалтай газруудад хэмжилт судалгааг хийж, холбогдох албан хаагч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг уламжлав.

Химийн болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглаж /хэрэглэж/ байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэстэй хамтран холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг хийж дуусган, дүнг нэгтгэн, илтгэх хуудсыг ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон холбогдох байгууллагуудад хүргүүлээ. Мөн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн ажил зохион байгуулж зөрчил арилгах талаар чиглэл өглөө.

Аймгийн Эрдэнэ сумын нутагт XV-08751 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Нэгүүн дриллинг" ХХК, Чандмань сумын нутаг дахь MV-00011956 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Гоби коул энд энержи" ХХК-ий Зээгтийн нүүрсний ил уурайд 2019 онд ус ашиглуулах дүгнэлтийг гарган тус тус хүргүүлэв.

Аймгийн Цээл, Тонхил, Бугат сумдын нутаг дэвсгэрт ашигт малтмалын үйл ажиллагаа явуул буй "Алтайн хүдэр" ХХК-ий Таяннуурын төмрийн уурхай, "Цогц эрин транс" ХХК-ий Бөөрөгийн алтны шороон ордын уурхайн 2019 оны байгаль орчны менежмийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцан зөвлөн туслах арга хэмжээ авч ажиллах зорилгоор газрын даргаар удирдамж батлуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/154 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг, БОАЖЯ, Уул уурхай,

хүнд үйлдвэрлэлийн яамны төлөөлөл хамтран 2019 оны 06 дугаар сарын 22-24-ний хооронд дээрх газруудад ажиллаж байна.

### АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, МХЕГ-ын даргын 2019 оны 01/202 дугаар хяналт шалгалтын удирдамжийн дагуу шалгасан байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар 96.5 хувиар үнэлэгдэв.

Улсын байцаагчийн нормативыг баримтлан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудаас 2019 онд 265 объектод 434 төлөвлөгөөт хяналт шалгалт, 101 объектод 128 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тус төлөвлөгөөний дагуу 320 объектод хяналт шалгалт, 104 объектод зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв. /Хяналт шалгалтад хийхээр төлөвлөсөн 17 объект, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн 6 объект үйл ажиллагаа явуулаагүй байна./

Шилэн хяналтын системд хийж гүйцэтгэсэн хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ, бусад хяналтын мэдээллийг бүрэн орууллаа.

Тайлант хугацаанд 4887 зөрчил /72 хяналтын хуудасны асуумжаар/ илрүүлсний 20.0%-ийг шалгалтын явцад арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 160 албан шаардлага, нөхөн төлбөр ногдуулсан, бүтээгдэхүүн хураасан, үйл ажиллагаа зогсоосон, сэргээсэн 21 акт, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөлийн 42 дүгнэлт үйлдэж ажиллав.

Зөвлөн туслах үйлчилгээгээр илэрсэн зөрчлийг арилгуулахаар 73 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Эрх бүхий албан тушаалтны 13 зөрчлийн хэрэг, зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 85 хэрэг нээж, 1 зөрчлийн хэргийг харъялалын дагуу шилжүүлж, 1 зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 62иргэн, 34 хуулийн этгээдэд нийт 61620.0 мянган төгрөгний торгууль, 150.0 мянган төгрөгний нөхөн төлбөр ногдуулав.

Биелэлтийг бүрэн хангуулах ажлыг зохион байгуулж ажилласны үр дүнд ногдуулсан торгуулийн 82.4% буюу 50770.0 мянган төгрөг, нөхөн төлбөрийг 100% барагдууллаа.

Хуулиар эрх олгогдсон сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид тухайн сумын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа бөгөөд 4 зөрчилд Зөрчлийн тухай хуулиар нийт 1750.0 мянган төгрөгний торгууль, 150.0 мянган төгрөгний нөхөн төлбөр ногдуулсан байна.

Засгийн газрын 311 дүгээр тогтоол болон дотоод хяналтын журам, хяналт шалгалтыг хэрхэн хийх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

**Хоёр. Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар,  
эрүүл ахуйн бодлогын хүрээнд:**



**Эмчилгээний чанар,эм биобэлдмэл,халдвар судлалын хяналтаар:**

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, төрөх, эмэгтэйчүүд, мэс заслын тасгаас арчдасны 100, ариун материалын 11, агаарын 8 сорьц, эмчилгээний хоолны 5 дээж авч МХГ-ын Нэгдсэн лабораторид шинжлүүлж байна.

**Гурав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

**Мал үржлийн хяналтын чиглэлээр:**

Есөнбулаг сумд үйл ажиллагаа явуулж буй “Торгон сүрэг” ХХК-ий мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн №1.15.2 кодтой “Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар үнэлэхэд 27.4%-аар бага эрсдэлтэй, хууль тогтоомжийн хэрэгжилт 72%-тай байна.

Сумдад үйл ажиллагаа явуулж буй мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 6 нэгжид “Дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмж” хүргүүлэв.

**Мал эмнэлгийн хяналтаар:**

МХЕГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу сумдын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлж, МХГ-ын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт “Хууль эрх зүй болон дотоод хяналт”-ын чиглэлээр байгууллагын дотоод хяналтын ажилтантай хамтран салбарын сургалт зохион байгуулахад 10 сумын 23 аж ахуйн нэгжийн малын эмч нар оролцож, санал бодлоо солилцлоо.

2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баян-Уул сумын “Үнэгт-Улаан” ХХК, “Намын гол” БГБХ-тай нөхөрлөл, Дэлгэр сумын “Хонгор мөрөн” ХХК-ий үйл ажиллагаанд МХГ-ын даргын баталсан Зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөрийн дагуу №1.15.1 “Ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээний мал эмнэлгийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар шалгаж эрсдэлийн бүлгийг тогтооход “Үнэгт-Улаан” ХХК, “Намын гол” БГБХ-тай нөхөрлөлийн мал эмнэлэг 74 оноо буюу 17%-аар бана, “Хонгор мөрөн” ХХК-ий мал эмнэлэг 140 оноо буюу 33%-аар дунд эрсдэлтэй үнэлэгдэж, шилэн хяналтын системд оруулан баталгаажуулав. Баян-Уул сумын “Ачад” ХХК-ий мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйл ажиллагаагаа зогсоосон байна.

**Дөрөв. Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

**Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтаар :**

Цээл сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Алтайн Хүдэр ХХК-ийн Таян нуурын Уурхай болон тэдний туслан гүйцэтгэгч 6 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулан ажиллав.

Мөн МХЕГ-ын даргын 2019 оны 01/36 дугаар удирдамжийн дагуу 11 аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг

арилгуулах зорилгоор 11 байгууллагад улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлэв.

**Авто замын хяналтаар:**

Алтай-Ховд чиглэлийн улсын чанартай авто замд төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг үйлдэж хүргүүлэв.

МХЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 5 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1 аж ахуйн нэгжид шийтгэврийн арга хэмжээ тооцож шалгалтын дүнг МХЕГ-т хүргүүлж ажиллав.

**Хэмжилзүйн хяналтаар:**

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2019 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Амар-Алтай ХХК-ны зуухны үйл ажиллагаанд Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагчтай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн хэмжүүрийн улсын шалгагч нь худалдаа үйлчилгээнд ашиглагдаж буй 9 жин, аймгийн төв болон сумдад үйлчилгээ үзүүлж буй 8 шатахуун түгээх станцын 16 шингэн хэмжигчдэд ээлжит болон анхдагч баталгаажуулалтыг хийж гүйцэтгэлээ.

**Нийгмийн хамгаалалын хяналтаар:**

2019 оны төлөвлөгөөний дагуу Алтайн хүдэр ХХК, Алтайложистик ХХК-дад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, тус бүрд нь улсын байцаагчдын хамтарсан албан шаардлага хүргүүлсэн ба өмнөх албан шаардлагын хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт хийхэд хангалтгүй байх тул Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтаар тус бүрд нь 500.0 мянган төгрөгийг шийтгэлийн арга хэмжээ ногдуулав.

**Эрчим хүчний хяналтаар:**

МХЕГ-ын даргын баталсан 01/55 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу 3 объектод хяналт шалгалт хийж 2 объектод 15 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллав.

Есөнбулаг сумын Харзат багийн иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу “Чавгын Шанд” ХХК-д хяналт шалгалт хийж 500.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

**Газар, геодези зураг зүйн хяналтаар:**

2019 оны төлөвлөгөөний дагуу Дарив, Тонхил сумд үйл ажиллагаа явуулж байгаа 2 байгууллага, 3 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж улсын байцаагчдын хамтарсан 5 албан шаардлага хүргүүлж ажиллав.

**Автотээвэр:**

МХЕГ-ын 2019 оны 3-р сарын 21-ний өдрийн 01/134 дугаартай удирдамжаар Алтайн Хүдэр ХХК-ий гэрээт тээвэрлэгч 24 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх

хяналт хийсэн дүнг нэгтгэн боловсруулж танилцуулга, хавсралт хүснэгтээр судалгаа, нэгтгэл гарган МХЕГ-ын ДБХГазарт хугацаанд нь хүргүүлэхэд бэлэн болголоо.

6-р сарын төлөвлөгөөний дагуу таксийн үйлчилгээний Хурд зам Алтай ХХЪ-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийхээр мэдэгдэл хүргүүлэн шалгалтын бэлтгэл ажлыг хийж байна.

**Өргөх механизм:**

6-р сарын төлөвлөгөөний дагуу Тайшир-Гуулингийн Усан Цахилгаан Станцын өргөх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр,

Иргэн Ц.Батсүхийн эзэмшлийн авто кранд төлөвлөгөөт Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр мэдэгдэл хүргүүлж, шалгалтын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Визард экспресс консалтинг ХХК-тай хамтран зохион байгуулсан мэргэжил олгох, давтан сургах сургалтын материалыг ирүүлж, үнэмлэх баталгаажуулах, эздэд нь олгох, өргөх механизмын мэдээллийн санг баяжуулах ажлыг хийж байна.

**Геологи, уул уурхайн хяналтаар:**

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуй нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3 чиглэлээр хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчдын албан шаардлага хүргүүлэн зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль ногдуулав.

**Тав. Нэгдсэн лаборатори:**

Лабораторид 3 байгууллага, 8 аж ахуйн нэгж, 1 иргэн, 5 цайны газраас ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 13 сорьцод 58 үзүүлэлтээр, ундны усны 13 сорьцод 52 үзүүлэлтээр, архины 2 сорьцод 10 үзүүлэлтээр, хуванцар савны 2 сорьцод 14 үзүүлэлтээр, нэрмэл усны 1 сорьцод 4 үзүүлэлтээр, гадаад орчны арчдасны 40 сорьцод 120 үзүүлэлтээр, бохир усны 2 сорьцод 8 үзүүлэлтээр, хөрсний 1 сорьцод 4 үзүүлэлтээр, эмнэлгийн дотоод халдварын: нэрмэл усны 1 сорьцод 4 үзүүлэлтээр, агаарын 3 сорьцод 9 үзүүлэлтээр, ариун материалын 13 сорьцод 13 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээ хийхэд ундны усны 9 сорьц 11 үзүүлэлтээр / 2 сорьцод нянгийн тоо стандартаас 15-98 – аар их, нэрмэл усны 1 сорьц 1 үзүүлэлтээр /нянгийн тоо стандартаас 150-аар их/ 8 сорьцод магнийн хатуулаг стандартаас 22-28.6 мг/л–ээр их/стандартын шаардлага хангаагүй.

Шинжилгээний төлбөр 120.5 мянган төгрөг бичигдсэн.

**Зургаа. Бургастайн хилийн Экспорт, импорт хил хорио цээрийн хяналтын хэлтэс**

Бургастай боомтын орох чиглэлд Монгол Улсын хилээр 1267 тээврийн хэрэгсэл орж ирснээс гадаад 1248 тээврийн хэрэгсэл, Монгол Улсын 19 тээврийн хэрэгсэл, 1277 зорчигч орж ирснээс Монгол Улсын иргэн 30, гадаадын иргэн 1247 орж ирсэн.

Гарах чиглэлд Монгол Улсын хилээр 1265 тээврийн хэрэгсэл гарснаас тус улсын 18 тээврийн хэрэгсэл гарсан байна. Зорчигчдын тухайд 1280 иргэн гарснаас гадаадын иргэн 1252, Монгол Улсын 28 иргэн тус тус зорчсон байна.

Тус боомтоор 6 дугаар сард 118112.7тн төмрийн хүдрийн баяжмал экспортлогдож, импортоор Цементийн цлинкэр 953.95тн, машины сэлбэг 15тн, нүүрс 60 тн орсон байна.

#### АРВАН ХОЁР. СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ТАЛААР:

Алтай сум “Залуучуудын чуулга уулзалт”-ыг 6 сарын 15-16-ны хугацаанд зохион байгуулж 17-35 насны 97 залуу хамрагдаж тус чуулганаар сумын залуучуудын холбооны 4 жилийн ажлын тайлан, цаашид хийж хэрэгжүүлэх ажил, сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн шинэчлэгдсэн журам, Тогтвортой хөгжилд залуусын оролцоо сэдэвт сургалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн танилцуулга, сумын Залуучуудын судалгаа зэрэг сургалт мэдээлэл хийгдэж Залуучуудын холбоо тэргүүлэгч гишүүдээ шинээр сонгож томиллоо.

Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар “Дэлхийн Зөн” ОУБ-тай хамтарч сумын ажилгүй 20 иргэнд төсөл хэрхэн боловсруулах, төслийн арга зүй, бүрдүүлэх материал, төслийн бүтцийн талаар сургалт зохион байгуулж, сумын ажилгүй 30 иргэнд газар тариалан эрхлэлт, төмс хөтөлбөр, Хүлэмж хөтөлбөрүүдийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Бигэр сумд Япон улсын иргэдийн 8.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд гэр хүлэмж байгуулагдан 1.25 га талбайг хашиж хамгаалан 20000 ш харганыг үрээр тариалах ажлыг хийж дууслаа.

Жаргалан сум “Дэлхийн зөн” Олон улсын байгууллагатай хамтран “Малчдын чуулга уулзалт”-ыг зохион байгуулж, энэ үеэр сумын өсвөр үе, залуучуудын дунд мэдээлэл сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг хийж 128 иргэн хамрагдсан байна.

Шарга сумын Засаг даргын Тамгын газар “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан сумын ЗДТГ, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг хамтран хүүхдийн чуулган зохион байгуулсан байна.

Тайшир сумын хагас жилийн мал тооллогын дүнгээр нийт 174553 мал тооллогдсон байна. Үүнээс: тэмээ 723, адуу 6252, үхэр 5005, ямаа 93607, хонь 68966 өмнөх оны жилийн эцсийн мал тооллогоос 41.0 толгой мал буюу 76% өссөн дүнтэй байна.

Мөн ХХҮГ-аас “Ногоон байгууламж” нэмэгдүүлэх төсөл бичиж дэмжигдэн 2851800 төгрөгний санхүүжилт авч 06 дугаар сарын 20-ноос эхлэн 10 иргэнийг түр ажлын байраар хангалаа.

Тонхил сум “Эртэч Тонхилчууд” өглөөний гүйлтийн арга хэмжээг зохион байгуулж, хаалтанд зориулсан Гар бөмбөгийн тэмцээн шоу цэнгүүнийг зохион

байгуулсан байна. “Эртэч Тонхилчууд” өглөөний гүйлтийн арга хэмжээ 2019 оны 03 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн 2019 оны 06 сарын 14-ны өдрийг дуустал нийт 43 удаагийн гүйлт болсон бөгөөд тасалдалгүй ирсэн хүмүүсийг шагнаж, урамшуулжээ.

Цогт сумын Төгрөг багийн Хаяа, Баян-Өндөр багийн Сухайт, Баянтоорой тосгоны Тэгш, Долоот, Баянбулаг, Шугуйд нийтдээ 19 га талбайд тариалалт хийснээс хүнсний ногоо 13.62 га, малын тэжээл 5.38 га талбайд тариалсан байна.